



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 8/68

Улаанбаатар хот


Баримтлах чиглэл батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Холбогдох байгууллагуудад энэхүү баримтлах чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээг авч ажиллахыг Радио телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлого зохицуулалтын газар /А.Золзаяа/-т даалгасугай.

ДАРГА



Б.ЧИНБАТ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын
даргын 2020 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн
068 дугаар тушаалын хавсралт

ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХЭД ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд энэхүү чиглэлийг баримтална.

1.2 Энэхүү баримтлах чиглэлийн зорилго нь цахим орчинд хүүхдийг эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөхүйц мэдээ мэдээлэл, агуулга, харилцаанаас шалтгаалсан эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад оршино.

1.3 Энэхүү баримтлах чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.
Үүнд:

- 1.3.1 Цахим орчинд хүүхэд хамгаалах бодлого, зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байх;
- 1.3.2 Хүүхдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, оролцох, хөгжих, хувийн нууцлалтай байх эрх, тэдний дээд ашиг сонирхлыг эн тэргүүнд хангах;
- 1.3.3 Мэдээллийн технологийн дэвшлийг хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхэд давуу тал болгон ашиглах;
- 1.3.4 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийт, хүүхдийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан, харилцан уялдаатай, нэгдмэл цогц байх.

Хоёр. Хамрах хүрээ, хэрэгжүүлэх чиглэл

2.1 Энэхүү баримтлах чиглэлийг Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн бүх шатны байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийт, хүүхэд хэрэгжүүлнэ.

2.2 Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагааг дараах гурван чиглэлээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.2.1 Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 2.2.2 Техник, технологийн чадамжийг бэхжүүлэх;
- 2.2.3 Олон нийтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх.

2.3 Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэлийг хэрэгжүүлэхэд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны, орон нутгийн байгууллага, боловсролын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд зохион байгуулалтыг хийж ажиллана.

Гурав. Нэр томьёо

3.1 Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэх зарим нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- 3.1.1 **Хүүхэд**¹ (child) гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг;
- 3.1.2 **Өсвөр үе**² (teenagers) гэдэгт 10-19 насны хүнийг;
- 3.1.3 **Цахим орчин** (online) гэдэгт интернэт протокол ашиглан өгөгдлийг дамжуулах боломж бүхий харилцан холбогдсон компьютеруудын дэлхий даяар тархсан сүлжээ бөгөөд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хамтын харилцаа холбоо тогтоох, мэдээллийг бүхий л хэлбэрээр үүсгэх, боловсруулах, түгээх, хүлээн авах боломж бүхий бодит бус (виртуаль) орон зайг;
- 3.1.4 **Цахим орчинд хүүхэд хамгаалал** (child online protection) гэдэгт хүүхэд бүрийг цахим орчин дахь аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх, эрсдэлт нөхцөл байдалд орохоос урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг;
- 3.1.5 **Цахим орчинд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ** (response service of child online protection) гэдэгт цахим орчин дахь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлыг үнэлэх, аюулгүй байдлыг хангах, холбон зуучлах, сэтгэл зүйн болон мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, нийгмийн хэвийн харилцаанд дасган зохицуулах үе шат бүхий үйл ажиллагааг;
- 3.1.6 **Интернэт түргэн тусламжийн утас** (hotline) гэдэгт цахим орчинд хүүхдийн эрх аливаа хэлбэрээр зөрчигдсөн талаарх мэдээ мэдээлэл, гомдлыг шуурхай хүлээн авч, холбон зуучлах харилцаа холбооны шууд сувгийг;
- 3.1.7 **Оролцогч талууд** (stakeholders) гэдэгт цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалахад оролцогчид буюу төрийн бодлого гаргагч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, сургалтын болон боловсролын байгууллага, багш сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, эцэг эх, хүүхдийг;
- 3.1.8 **Нийгмийн мэдээллийн сүлжээ** (social media network) гэдэгт интернэт болон ухаалаг технологид ³ суурилсан блог, цахим хуудас, вики⁴,

¹ Хүүхдийн эрхийн тухай конвенци 1 дүгээр зүйлд тодорхойлсон.

² Олон улсын баримт бичгүүдэд “өсвөр үе” гэсэн нэршлийг тайлбарлаагүй бөгөөд Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сан болон түүний бусад төрөлжсөн байгууллагууд энэ утгаар ойлгож хэрэглэдэг.

³ Ухаалаг технологи гэж компьютер, гар утас, таблет гэх мэт интернэтэд холбогддог аливаа хэрэгслийг ойлгоно.

⁴ Олон хэл дээрх, чөлөөт агуулга бүхий цахим нэвтэрхий толины нэг хэлбэр юм.

нийгмийн болон мэргэжлийн сүлжээгээр⁵ олон нийтийн дунд мэдээлэл түгээх, олж авах, солилцох, сурталчлан таниулах, сэтгэгдэл, санал бодлоо илэрхийлэх, хуваалцах боломж бүхий харилцааны хэрэгслийг;

- 3.1.9 **Цахим орчинд хүүхдэд учирдаг нийтлэг эрсдэл**⁶ (the most common threats children face online) гэдэгт хүүхдийн эрх аливаа хэлбэрээр зөрчигдөх явдал буюу эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж, улмаар хор хохирол учруулж буй нөхцөл байдал үүсэхийг;
- 3.1.10 **Цахим орчин дахь зүй бус үйлдэл** (inappropriate behavior online) гэдэгт сэтгэл зүйн дарамт шахалт үзүүлэх, түрэмгийлэх, айлган сүрдүүлэх, гэмтээх, доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэх, насанд хүрээгүй хүмүүсийн хувийн мэдээллийг залилан мэхэлж авах, ашиглах, хууль бусаар боловсруулах, цахим хэрэгслээр дамжуулан түгээх, насанд хүрээгүй хүнийг бусдаас тусгаарлах, ганцаардуулах, амиа хорлох хүртэлх эрсдэлд оруулдаг зориудын, санаатай үйлдлийг;
- 3.1.11 **Хортой контент**⁷ (harmful content) гэдэгт хуулиар хориглоогүй боловч хүүхдийн нас, бие, сэтгэлзүйд тохироогүй эсхүл ухамсар, сэтгэхүй, хөгжил хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аливаа зохисгүй агуулгыг;
- 3.1.12 **Хориотой контент** (illegal content) гэдэгт хуулиар хориглосон аливаа агуулгыг;
- 3.1.13 **Цахим орчинд үйлддэг гэмт хэрэг** (cybercrime) гэдэгт цахим орчныг ашиглан бусдын бие махбод болон сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хор хохирол учруулж буй аливаа хууль бус үйлдлийг;
- 3.1.14 **Шүүлтүүрийн програм хангамж** (filter software) гэдэгт хортой болон хориотой контентыг таних, хязгаарлах, хаах боломж бүхий мэдээллийн технологийн системийг;
- 3.1.15 **Эцэг эхийн хянах хэрэглүүр** (parental controls) гэдэгт хэрэглэгчийн интернэтэд холбогдсон компьютер болон бусад ухаалаг төхөөрөмжид суурилуулах боломжтой, үйлдлүүдийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаах, цагийн хязгаар тогтоох, сонгосон цахим хуудасны хандалтыг хязгаарлах зэрэг тохируулгатай, нууц үгээр хамгаалагдсан програм хангамжийг;
- 3.1.16 **Дэлгэцийн дон**⁸ (screen addiction) гэдэгт тодорхой нэг хүсэл сонирхолдоо автаж, удаан хугацаагаар⁹ цахим орчинд идэвхтэй байхыг;
- 3.1.17 **Цахимаар дарамтлах** (Cyberstalking) гэдэгт интернэт орчинд компьютер, гар утас бусад ухаалаг хэрэгслийг ашиглан хэн нэгнийг

⁵ Нийгмийн болон мэргэжлийн сүлжээ гэж Facebook, Twitter, Instagram, LinkedIn, Flickr, YouTube гэх мэт.

⁶ Үүнд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг (sexual abuse and exploitation), цахимаар дээрэлхэлх (cyber bullying), бэлгийн дарамт (sexual harassment), хүүхдийг садар самуунд уруу татах, хүүхдийн биеийг үнэлэх (child pornography and child prostitution), зохисгүй эсвэл хүсээгүй контент хүлээн авах (meet up inappropriate or unsuitable content), хүний наймааны золиос болох (to be a victim of trafficking), дэлгэцийн дон (screen addiction) зэргийг хамруулан ойлгоно.

⁷ Энэ нь амиа хорлох, үзэн ядах, дээрэлхэх зэргийг өөгшүүлсэн, зааварласан, уриалсан шинжтэй байна.

⁸ Дэлгэцийн хамааралтай болох гэж өөрөөр нэрлэдэг.

⁹ Нэг удаад 2 цагаас илүү хугацаа

айлгах, заналхийлэх, ичээх зорилгоор хууль бусаар мэдээлэл цуглуулж, санаатайгаар олон нийтэд түгээж, бусдад сэтгэл санааны хор хохирол учруулж буй ноцтой үйлдлийг;

3.1.18 **Цахимаар дээрэлхэх** (Cyberbullying) гэдэг нь дээрэлхэлийн нэг хэлбэр бөгөөд текстэн зурвас, зураг, видео, гар утасны камераар авсан бичлэг, дүрс, чат, сэтгэгдэл, цахим шуудан зэрэг аливаа хэлбэрээр цахим орчинд бусдад дарамт, шахалт үзүүлэх үйлдлийг;

3.1.19 **Цахимаар эргүүлэх** (Cybergrooming) гэдэгт насанд хүрсэн этгээд зүсээ буруулан, цахим орчинд хүүхдийн итгэлийг олж аван, улмаар түүнтэй найз нөхдийн дотно харилцаа холбоо үүсгэн, бэлгийн эсхүл садар самуун шинжтэй үйлдэлд ашиглах зорилгоор урьдчилан төлөвлөж, зохион байгуулсан гэмт үйлдлийг;

Дөрөв. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэл

4.1 Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ (анализ) хийж, цахим орчинд хүүхэд хамгаалах талаар шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

4.2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйл “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-д нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

4.3 Интернэт, цахим хуудас, цахим тоглоомын үйлчилгээ эрхлэгчдэд тавих нөхцөл, шаардлагыг шинэчлэн боловсруулна.

4.4 Зохисгүй агуулга, хортой контент, худал хуурмаг мэдээллийг тодорхойлох чиг үүрэг бүхий хараат бус бие даасан зөвлөлийг байгуулан ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

4.5 Цахим орчинд хүүхэд хамгааллын асуудлаар зарим нэр томъёог холбогдох байгууллагаар хянуулан, батлуулах арга хэмжээ авна.

4.6 Цахим орчинд хүүхдэд сөрөг нөлөөтэй мэдээ мэдээлэл, контентыг хянах, хязгаарлах, хаах шүүлтүүрийн програм ашиглах (filtering), агуулгыг техникийн тусламжтай эрэмбэлэн тогтоох (rating), хор хөнөөлтэй агуулгыг шошиголох (labeling), хүүхдийн насыг магадлах систем бий болгох (age verification system) техникийн шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх хууль, эрх зүйн тогтолцоог бий болгоно.

4.7 Цахим орчны зохистой хэрэглээний стандартыг хүүхдийн насны ангилалд тулгуурлан боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулна.

4.8 Цахим орчин дахь зүй бус үйлдлээс хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах, хохирохоос урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.9 Цахим орчинд хүүхдийн эрхэд халдсан гэмт үйлдлийг илрүүлэх, шуурхай таслан зогсоох, шалган шийдвэрлэх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.10 Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд болон интернэт холболт бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хэрэглэгчийн шүүлтүүрийн програм заавал ашигладаг байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.11 Сургууль, сургалтын байгууллага цахим орчинд хүүхэд хамгааллын талаар бодлого, төлөвлөлттэй болно.

- 4.12 Тоон хэлбэрээр түгээгдэж буй аливаа мэдээлэлд насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг байршуулж хэвшүүлнэ.
- 4.13 Цахим орчинд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тогтолцоог эрх зүйн орчинд бий болгоно.

Тав. Техник, технологийн чадамжийг бэхжүүлэх чиглэл

- 5.1 Цахим бүртгэлийн тогтолцоонд суурилсан хүүхдийн насыг магадлах системийг бүрдүүлнэ.
- 5.2 Хүүхдэд сөрөг нөлөөтэй мэдээ мэдээлэл, контентыг илрүүлэх, хянах, хязгаарлах, хаах технологийн шийдлийг ¹⁰ төрөлжүүлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 5.3 Хүүхэд зохисгүй агуулга үзэх, хууртах, төөрөгдөх байдлаас сэргийлж, домэйн нэр үнэн зөв байгаа эсэхэд хяналт тавина.
- 5.4 Нийтийн номын сан, сургуулийн орчинд хүүхэд зохисгүй агуулга үзэхээс сэргийлсэн шүүлтүүрийн програмыг суурилуулан ажиллуулна.
- 5.5 Цахим орчинд хүүхдийн эрх аливаа хэлбэрээр зөрчигдсөн талаарх мэдээ мэдээллийг хүлээн авах, гомдол гаргах “Интернэт түргэн тусламжийн утас” ажиллуулна.
- 5.6 Цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн талаарх аливаа дуудлага, мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ, дүгнэлт хийх, тоо баримт боловсруулах нэгдсэн мэдээллийн цахим санг (платформ) хөгжүүлнэ.
- 5.7 Шүүлтүүрийн програм хангамж хөгжүүлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.8 Шүүлтүүрийн програм хангамжийг бүх нийтээр хэрэглэх боловсролыг олгоно.
- 5.9 Шүүлтүүрийн програм хангамжийн хэрэглээний түвшинг тогтмол судалж, шинэчлэн хөгжүүлнэ.

Зургаа. Олон нийтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэл

- 6.1 Ерөнхий боловсролын сургуулийн зохих шатны сургалтын хөтөлбөрт цахим орчны зөв зохистой хэрэглээний агуулгыг тусгаж хэрэгжүүлнэ.
- 6.2 Олон нийт, хүүхэд, өсвөр үеийнхэнд цахим дарамтын тухай мэдлэг ойлголтыг өгөх, түүний сөрөг нөлөө, хор уршгийг таниулах, хэрхэн урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгасан цуврал зөвлөмжийг боловсруулан түгээнэ.
- 6.3 Цахим орчны зөв зохистой хэрэглээ болон цахим орчинд хүүхэд хамгааллын талаар оролцогч талуудад чиглэсэн удирдамж зөвлөмжийг бэлтгэн хүргэнэ.
- 6.4 Хүүхэд, эцэг эхчүүд, олон нийтэд зориулсан сургалтын модулиудыг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 6.5 Шүүлтүүрийн програм хангамжийг бүх нийтээр хэрэглэх дадлыг хэвшүүлнэ.
- 6.6 Цахим орчны зөв зохистой хэрэглээний талаарх бүх нийтийн мэдлэг ойлголтыг төлөвшүүлэхэд чиглэсэн контентыг тогтмол бэлтгэж, мэдээллийн сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.

¹⁰ Шүүлтүүрийн програм хангамж

- 6.7 Хүүхдийн хөгжил, сэтгэхүй, төлөвшилд эерэг нөлөөтэй контентын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 6.8 Жил бүр “Аюулгүй интернэтийн өдөр”¹¹-ийг зохион байгуулж, шат шатанд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.9 Цахим орчинд зохистой хэрэглээ болон амьд, дотно харилцааг бий болгох зорилгоор гэр бүл, сургууль, нийгмийн орчинд долоо хоног бүрийн нэг өдрийг “Интернэтгүй өдөр” болгож хэвшүүлнэ.
- 6.10 Өрхийн болон сургуулийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад чиглэсэн цахим дон буюу дэлгэцийн хамааралтай болсон хүүхдийн шинж тэмдгийг тодорхойлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн туслах чиглэлээр мэдлэг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

---ooOoo---

¹¹ “Аюулгүй Интернетийн өдөр” (Safer Internet Day/SID)-ийг жил бүрийн 2 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн хоёр дахь өдөр дэлхий даяар тэмдэглэн өнгөрүүлдэг. 2004 оноос Европын улсуудад анх тэмдэглэсэн энэхүү санаачилга нь интернэтийн дэвшлийг эерэг, аюулгүй, хариуцлагатай байдлаар ашиглах, зөв зохистой хэрэглээг бий болгох талаар хүүхэд залууст ойлгуулан таниулах зорилготой. Монгол Улс 2018 оноос “Аюулгүй Интернетийн өдөр”-ийг тэмдэглэж эхэлсэн.